



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 05

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ерөө сумын Засаг даргын Тамгын газрын Газрын даамал Э.Ариунбаттай холбоотой асуудлаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ёндонжамц

-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

Б.Болорзул

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Ч.Энхтуяа

-Аудитын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

М.Нямсүрэн


-Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Ж.Отгонхүү

-Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 02 дугаар сарын 28-ны дотор шийдвэрлэхийг ажлын хэсгийн ахлагч /Д.Ёндонжамц/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө СУВДАА